# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 07 дугаар сарын 24
№27 (1422)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 119. | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай | | 1241 |
| 120. | Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1296 |
| 121. | Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1297 |
| 122. | Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1298 |
| 123. | Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1299 |
| 124. | Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1301 |
| 125. | Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1302 |
| 126. | Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1303 |
| 127. | Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1304 |
| 128. | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1305 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 129. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 28 | 1306 |
| 130. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 38 | 1319 |

| | | | |
|---|---|---|---|
| 131. | “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 43 | 1321 |
| 132. | Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай | Дугаар 46 | 1323 |
| 133. | Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай | Дугаар 49 | 1327 |
| 134. | Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 54 | 1329 |
| 135. | Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай | Дугаар 56 | 1331 |

[illegible]

| | | |
|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | |
|---|---|---|---|
| ᠑᠙᠔. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠔᠖ | ᠑᠙᠙᠑ |
| ᠑᠙᠕. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠔᠕ | ᠑᠙᠙᠖ |
| ᠑᠙᠖. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠕᠖ | ᠑᠙᠙᠗ |
| ᠑᠙᠗. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠕᠖ | ᠑᠙᠙᠙ |
| ᠑᠙᠘. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠕᠙ | ᠑᠙᠙᠑ |
| ᠑᠙᠙. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠙᠔ | ᠑᠙᠑᠖ |
| ᠒᠐᠐. | [illegible] | ᠳᠤᠭᠠᠷ ᠙᠔ | ᠑᠙᠐᠖ |

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэхэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн механизм, карбон зах зээлийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

**2 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн хууль тогтоомж**

2.1.Уур амьсгалын өөрчлөлтийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Байгаль орчныг хамгаалах тухай хууль[2], Агаарын тухай хууль[3], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд төр, иргэн, хувийн хэвшил, санхүүгийн байгууллага, бусад оролцогч талуудын эрх, үүргийг зохицуулсан харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөлөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2] Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.
[3] Агаарын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.2.“давхар тооллого” гэж хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээх үйл ажиллагаанаас үүссэн бууруулалтын үр дүнг давхардуулан бүртгүүлэх, тайлагнах, ашиглах ажиллагааг;

4.1.3.“дасан зохицох” гэж уур амьсгалын өөрчлөлт бодитой бий болсон, эсхүл ирээдүйд тохиолдож болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчин, эдийн засаг, нийгмийн эмзэг байдлыг бууруулах, тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагааг;

4.1.4.“дүйцүүлэх” гэж иргэн, хуулийн этгээд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үүргийг биелүүлэх зорилгоор бусад этгээдийн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд баталгаажсан, бүртгэгдсэн бууруулалтын үр дүнг зохих журмын дагуу өөрийн үүрэгт дүйцүүлэн тооцуулахыг;

4.1.5.“карбон зах зээл” гэж карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглахтай холбоотой зах зээлийг;

4.1.6.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.7.“карбон нэгж” гэж бууруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.8.“ногоон санхүүжилт” гэж байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх, доройтлыг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжихэд чиглэсэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.9.“ногоон таксономи” гэж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон нэгдсэн шалгуур, ангиллыг;

4.1.10.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох, бууруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.11.“олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүн” гэж оролцогч талуудын зөвшөөрлөөр Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх, эсхүл олон улсын бусад бууруулалтын зорилгоор ашиглахад зориулан шилжүүлж, харгалзах тохируулгыг хийсэн бууруулалтын үр дүнг;

4.1.12.“бууруулалтын үр дүн” гэж уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан, ялгарахаас урьдчилан сэргийлсэн, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн, баталгаажсан, хэмжигдэхүйц үр дүнг нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцлээр, эсхүл хүлэмжийн хийн бус хэмжүүрээр илэрхийлснийг;

4.1.13.“сайн дурын карбон зах зээл” гэж хууль тогтоомжоор биелүүлэх үүргээс ангид, иргэн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үйл ажиллагаанд оролцох карбон зах зээлийг;

4.1.14.“урьдчилсан баталгаажуулалт” гэж итгэмжлэгдсэн, хараат бус этгээдээс төсөл, хөтөлбөр хэрэгжихээс өмнөх суурь түвшин, аргачлал, хүлээгдэж байгаа бууруулалтын үр дүн, бусад мэдээлэл нь холбогдох стандарт, шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх үйл ажиллагааг;

4.1.15.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч байгаа өөрчлөлтийг;

4.1.16.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.17.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар” гэж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, мэдрэг байдалтай, дасан зохицох чадавх хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, эдийн засгийн үр ашигт нь сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бүхий салбарыг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.20.“уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл” гэж уур амьсгалын аюулт үзэгдэл, эмзэг байдал, өртөмтгий байдлын харилцан нөлөөлөл, хамаарлаас үүсэх сөрөг үр дагаврын магадлал, хэмжээг;

4.1.21.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.22.“үндэсний карбон зах зээл” гэж Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.23.“Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах чиглэлээр тодорхойлсон зорилт, арга хэмжээг;

4.1.24.“үр дүнгийн баталгаажуулалт” гэж итгэмжлэгдсэн, хараат бус этгээдээс төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад бодитоор бий болсон сааруулалтын үр дүнгийн хэмжилт, тайлагналын мэдээлэлд үндэслэн холбогдох стандарт, аргачлалын дагуу шалган баталгаажуулах үйл ажиллагааг;

4.1.25.“харгалзах тохируулга” гэж давхар тооллогоос зайлсхийх зорилгоор олон улсад шилжүүлсэн сааруулалтын үр дүнг олон улсын аргачлалын дагуу хүлэмжийн хийн ялгарлын тэнцэлд нэмж, эсхүл хасаж тооцохыг;

4.1.26.“хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.27.“хүлэмжийн хий” гэж агаар мандалд дулааныг шингээж хадгалах шинж чанартай, байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлдөг нүүрстөрөгчийн давхар исэл, метан, азотын давхар исэл, гидрофторт нүүрстөрөгчид, перфторт нүүрстөрөгчид, хүхрийн гексафторид, азотын трифторид болон олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн бусад хийг;

4.1.28.“хүлэмжийн хийг шингээх” гэж ой, бэлчээр, ургамлын бүрхэвч, хөрс, ус, бусад экосистемийг ашиглах, геологийн, биологийн, физикийн, эсхүл технологийн аргаар хүлэмжийн хийг агаар мандлаас урт хугацаанд тогтвортой шингээх, хадгалах үйл ажиллагааг;

4.1.29.“хүлэмжийн хийн тооллого” гэж холбогдох хууль тогтоомж, журам, олон улсын аргачлалын дагуу улсын, салбарын, бүс нутгийн болон байгууллагын түвшинд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй дэлхийн агаар мандалд ялгаруулж, эсхүл агаар мандлаас шингээн авч байгаа хүлэмжийн хийг тооцоолох үйл ажиллагааг;

4.1.30.“хүлэмжийн хийн ялгарал” гэж хүлэмжийн хий агаар мандалд ялгарч гарахыг;

4.1.31.“хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.32.“хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.33.“хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасаж гарах цэвэр дүнг;

4.1.34.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг;

4.1.35.“эрсдэлийн сан” гэж хоёр болон олон талт карбон зах зээлийн төсөл, хөтөлбөрөөс үүссэн, баталгаажсан бууруулалтын үр дүн бүрэн, эсхүл хэсэгчлэн алдагдсан тохиолдолд нөхөн бүрдүүлэх зорилгоор тодорхой хувийг шилжүүлэх, ашиглах боломжгүйгээр хадгалж төвлөрүүлсэн санг.

**5 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Энэ хуулиар зохицуулах харилцаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах;
5.1.2.тэгш хүртээмжтэй шилжилтийг дэмжих;
5.1.3.олон улсын эрх зүйн хэм хэмжээг баримтлах;
5.1.4.эдийн засгийн үр ашигтай байх;
5.1.5.ил тод, нээлттэй байх;
5.1.6.талуудын оролцоог хангах;
5.1.7.уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийг тэргүүн ээлжид авч үзэх;

5.1.8.шинжлэх ухаан, инновацид суурилах;
5.1.9.уламжлалт мэдлэгийг ашиглах;
5.1.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

**6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1.Улсын Их Хурал уур амьсгалын өөрчлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг тусган батлах;

6.1.2.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төсөлд энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тусган батлах, хяналт тавих;

6.1.3.Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх тайлан, илтгэлийг сонсож, хэлэлцэх;

6.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

**7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хороог байгуулж, ажиллуулах;

7.1.2.Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны санал, зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах;

7.1.3.уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах;

7.1.4.хоёр болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах;

7.1.5.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн карбон зах зээлийн бодлого, ногоон санхүүжилтийн стратегийг батлах;

7.1.6.улсын болон орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ногоон төсөл, хөтөлбөрт зориулсан ногоон таксономийг батлах;

7.1.7.эрсдэлийн санд төвлөрүүлэх сааруулалтын үр дүнгийн хувь хэмжээг тогтоох;

7.1.8.энэ хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан карбон зах зээлийг зохицуулах, карбон кредитийг бүртгэх журам батлах;

7.1.9.хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журам батлах;

7.1.10.ногоон болон уур амьсгалын санхүүжилтийг бүртгэх, тайлагнах, ил тод байдлыг хангах журам батлах;

7.1.11.уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформын үйл ажиллагааны журам батлах;

7.1.12.хууль тогтоомжид заасан бусад.

**8 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг уялдуулан боловсруулах;

8.1.2.ногоон хөгжил болон урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийг дэмжих арга хэмжээг тодорхойлох;

8.1.3.ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах.

8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.2.1.ногоон таксономийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах.

8.3.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг боловсруулах;

8.3.2.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн карбон зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;

8.3.3.хоёр талт олон улсын хэлэлцээрийн хамтарсан хороодын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

8.3.4.олон талт карбон зах зээлийн үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих;

8.3.5.хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн татгалзахгүй тухай тодорхойлолт олгох;

8.3.6.хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох;

8.3.7.хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүнгийн шилжүүлэгт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох;

8.3.8.сайн дурын карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн татгалзахгүй тухай тодорхойлолт олгох;

8.3.9.техникийн хороо, мэргэжлийн зөвлөлийг байгуулах;
8.3.10.олон улсын гэрээгээр үүрэг хүлээсэн тайланг хянах, олон улсын байгууллагад хүргүүлэх;

8.3.11.карбон зах зээлийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний төлбөр, хураамж, шимтгэлийн хэмжээг тогтоох;

8.3.12.Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих;

8.3.13.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хэмжих, тайлагнах, баталгаажуулах журам батлах;

8.3.14.уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, журам батлах;

8.3.15.энэ хуулийн 7.1.10-т заасан журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.3.16.энэ хуулийн 7.1.9, 7.1.11-д заасан журмын төслийг боловсруулж, батлуулах;

8.3.17.бууруулалтын үр дүнг тооцох аргачлал, стандарт, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дэргэдэх техникийн хороогоор хэлэлцүүлж, түүний дүгнэлтэд үндэслэн батлах;

8.3.18.хууль тогтоомжид заасан бусад.

8.4.Төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.4.1.энэ хуулийн 6.1.1, 7.1.2-т заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.4.2.салбарын хэмжээнд хүлэмжийн хийн тооллоготой холбоотой мэдээллийг цуглуулах, мэдээллийн санд оруулах, тайлагнах, баталгаажуулах;

8.4.3.салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тооцох аргачлалыг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, хүлэмжийн хийн ялгарлыг тооцох;

8.4.4.салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

8.4.5.салбарын хэмжээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

8.4.6.хууль тогтоомжид заасан бусад.

**9 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн аймаг, нийслэлийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, гүйцэтгэлд хяналт тавина.

**10 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг энэ хуулийн 8.3.14-т заасан журмын дагуу хийнэ.

10.2.Энэ хуулийн 6.1.1, 7.1.2, 9.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, орон нутгийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг хангаж тайлагнана.

**11 дүгээр зүйл.Үндэсний зохицуулагч байгууллагын чиг үүрэг**

11.1.Үндэсний зохицуулагч байгууллага нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хүлэмжийн хийн үндэсний тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтыг удирдан зохион байгуулах;

11.1.2.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийн жилийн тайлан болон энэ хуулийн 27.3-т заасан тайланг боловсруулж, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлэх;

11.1.3.карбон зах зээлийн хүрээнд үүсэх карбон кредитийн болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнгийн бүртгэлийн системийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

11.1.4.карбон зах зээлийн төсөл, хөтөлбөрийн санал, баримт бичгийг хянах, шаардлага хангасан төслийг бүртгэх, холбогдох саналыг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

11.1.5.сааруулалтын үр дүнгийн бүртгэл, шилжүүлгийг хянах, давхар тооллогоос сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах;

11.1.6.хүлэмжийн хийн ялгарлын тэнцэлд харгалзах тохируулгыг хийх;

11.1.7.уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

11.1.8.ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэр, зориулалт, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг бүртгэх, хянах, тайлагнах;

11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн, баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд төвлөрүүлэн, энэ хуулийн 7.1.8-д заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх;

11.1.10.хууль тогтоомжид заасан бусад.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

### 12 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ

12.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлын үнэлгээг жил бүр, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг таван жил тутам хийж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.2.Энэ хуулийн 8.3.14-т заасан журмын дагуу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг эдийн засаг, нийгмийн салбар, бүс нутаг тус бүрээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухаанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг тодорхойлно.

12.4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний, бүс нутгийн, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө боловсруулахад ашиглана.

12.5.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

12.6.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн гарах эдийн засгийн болон эдийн засгийн бус гарз хохирлын үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн[4] 20.3-т заасан журмын дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

### 13 дугаар зүйл.Хүлэмжийн хийн үндэсний тооллого

[4] Гамшгаас хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” хууль тогтоомжийн эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

13.1.Үндэсний зохицуулагч байгууллага хүлэмжийн хийн үндэсний тооллогын дүн, тайланг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжид нийцүүлэн боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

13.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэсний тооллогын үйл ажиллагаа, салбар хоорондын уялдаа холбоог хангах нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлж, тооллогын тайланд хяналт тавина.

13.3.Үндэсний зохицуулагч байгууллага хүлэмжийн хийн үндэсний тооллогын шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулах, баталгаажуулах, үндэсний нөхцөл, онцлогт тохирсон ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг тодорхойлох, шинэчлэх судалгааг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

13.4.Үндэсний зохицуулагч байгууллага хөгжлийн төлөвлөлт, холбогдох мэдээлэлд үндэслэн үндэсний түвшний хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөллийг боловсруулна.

13.5.Хүлэмжийн хийн үндэсний тооллого, хэтийн төсөөллийг боловсруулах аргачлал, хяналт, чанарын баталгаажуулалт хийх аргачлал, ялгарал, шингээлтийн итгэлцүүрийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

13.6.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллага хүлэмжийн хийн үндэсний тооллого хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээллийг гаргаж өгнө.

13.7.Хүлэмжийн хийн үндэсний тооллого нь улсын болон салбарын түвшинд хийгдэж, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын суурь мэдээлэл байна.

13.8.Хүлэмжийн хийн үндэсний тооллогын тайланг олон улсын гэрээ, тэдгээрийн хүрээнд батлагдсан холбогдох шийдвэр, удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд гаргаж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

**14 дүгээр зүйл.Харгалзах тохируулга хийх**

14.1.Хоёр болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг шилжүүлж,

хүлэмжийн хийн ялгарлын тэнцэлд харгалзах тохируулгыг хийхдээ дараах шаардлагыг хангана:

14.1.1.Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн байх;

14.1.2.олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүнг зөвшөөрсөн тухай тодорхойлолтод үндэслэсэн байх;

14.1.3.карбон бүртгэлийн системд бүртгэгдэж, давхар тооллого үүсгэхгүй байх;

14.1.4.харгалзах тохируулгыг холбогдох олон улсын гэрээнд нийцсэн журам, удирдамжийн дагуу хийх.

14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад Монгол Улсаас олон улсад шилжүүлэхээр зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгоогүй бууруулалтын үр дүн, карбон кредитэд харгалзах тохируулгыг хийхгүй.

**15 дугаар зүйл.Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ**

15.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хуулийн этгээд нь үйл ажиллагаанаас үүдэн ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг энэ хуулийн 18.8-д заасан аргачлалын дагуу тооцож, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 8.3.14-т заасан журмын дагуу хийж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, ДАВАН ТУУЛАХ

**16 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлт**

16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох  үндэсний төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд[5] заасан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол

[5] Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 21 дугээрт нийтлэгдсэн.

Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

16.3.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөнд заасан арга хэмжээг улсын болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлнэ.

16.4.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.16, 4.1.17-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг, салбарын дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.5.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, олон улсын төсөл, хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, хуульд заасан бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

**17 дугаар зүйл.Дасан зохицох арга хэмжээний үнэлгээ, тайлан**

17.1.Энэ хуулийн 11.1-д заасан байгууллага Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

17.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөний тайланг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжид нийцүүлэн боловсруулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ, ШИНГЭЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

**18 дугаар зүйл.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөлт**

18.1.Засгийн газар Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг таван жил тутам шинэчлэн батална.

18.2.Урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийн стратегийг хүлэмжийн хийн үндэсний тооллого, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн боловсруулна.

18.3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тодорхойлно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан стратеги, төлөвлөгөөнд хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгана.

18.5.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 8.4 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгаж хэрэгжүүлнэ.

18.6.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалзан үзнэ.

18.7.Хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

18.8.Үндэсний зохицуулагч байгууллага байгууллагын болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

18.9.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

18.10.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгана.

**19 дүгээр зүйл.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын үр дүнг тооцох, тайлагнах**

19.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 13.1-д заасан хүлэмжийн хийн үндэсний тооллого, холбогдох өгөгдөл, мэдээлэлд үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцно.

19.2.Үндэсний зохицуулагч байгууллага Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

19.3.Энэ хуульд заасан журмын дагуу хоёр болон олон талт карбон зах зээлийн хүрээнд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгогдсон төсөл, хөтөлбөрөөс үүссэн, баталгаажсан бууруулалтын үр дүнг талуудын тохиролцсоны үндсэн дээр Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын үр дүнд оруулан тооцож болно.

19.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжсэн үйл ажиллагаанаас бий болсон олон улсад шилжүүлээгүй, холбогдох журмын дагуу баталгаажсан бууруулалтын үр дүнг талууд тохиролцсоны үндсэн дээр Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын биелэлтэд тооцож болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## НОГООН САНХҮҮЖИЛТ

**20 дугаар зүйл.Ногоон санхүүжилт**

20.1.Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжинэ.

20.2.Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн байна.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтөд зардал, үр ашгийн тооцоо, эдийн засаг, нийгмийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэнэ.

20.4.Ногоон санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

20.4.1.улсын болон орон нутгийн төсөв;
20.4.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт;
20.4.3.дотоод, гадаадын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт;
20.4.4.гадаадын зээл, буцалтгүй тусламж;
20.4.5.байгаль орчин, уур амьсгалын сан;
20.4.6.хууль тогтоомжид нийцсэн бусад эх үүсвэр.

20.5.Ногоон санхүүжилтийг дараах санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийг ашиглан хэрэгжүүлж болно:

20.5.1.улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;
20.5.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;
20.5.3.батлан даалт;
20.5.4.зорилтот бонд, зээл;
20.5.5.төр, хувийн хэвшлийн болон олон улсын эх үүсвэртэй холимог санхүүжилт;

20.5.6.хууль тогтоомжид заасан бусад.

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ногоон санхүүжилтийн санхүүгийн хэрэгсэл, хөшүүрэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль[6], Өрийн удирдлагын тухай хууль[7], Татварын ерөнхий хууль[8] болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байна.

20.7.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон санхүүжилтийн шалгуур, ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байна.

**21 дүгээр зүйл.Ногоон санхүүжилтийн шалгуур, нийцэл**

21.1.Ногоон санхүүжилт нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх зарчмыг хангана.

21.2.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байна.

21.3.Ногоон санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулахад энэ хуульд заасан хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоо, холбогдох аргачлалыг баримтална.

[6] Төсвийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.
[7] Өрийн удирдлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 09 дүгээрт нийтлэгдсэн.
[8] Татварын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2019 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

**22 дугаар зүйл.Ногоон санхүүжилтийн ил тод байдал, хяналт**

22.1.Ногоон санхүүжилтийн мэдээлэл ил тод, нээлттэй, олон нийтэд хүртээмжтэй байна.

22.2.Уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнана.

Тайлбар: Энэ хуулийн 4.1.21-д заасан уур амьсгалын санхүүжилт нь 4.1.8-д заасан ногоон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд энэ хуульд "ногоон болон уур амьсгалын санхүүжилт" гэж дурдсан тохиолдолд уур амьсгалын санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамааруулан ойлгоно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## КАРБОН ЗАХ ЗЭЭЛ

**23 дугаар зүйл.Карбон зах зээлийн зохицуулалт**

23.1.Карбон зах зээл дараах төрөлтэй байна:

23.1.1.олон талт;
23.1.2.хоёр талт;
23.1.3.үндэсний;
23.1.4.дүйцүүлэх;
23.1.5.сайн дурын.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн үр дүнд бууруулалтын үр дүн, карбон кредит, олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүн үүснэ.

23.3.Карбон зах зээлийн үйл ажиллагаанд дараах үндсэн шаардлагыг хангана:

23.3.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах төрийн бодлого, зорилттой нийцсэн байх;

23.3.2.бодит, хэмжигдэхүйц, нэмэлт, баталгаажсан үр дүнд суурилах;
23.3.3.давхар тооллого үүсгэхгүй байх;
23.3.4.бууруулалтын үр дүн урт хугацаанд хадгалагдах;
23.3.5.байгаль орчин, эдийн засаг, нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх;

23.3.6.сонирхогч талуудын тэгш оролцоог хангах, үр ашгийг шударгаар хуваарилах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

23.3.7.тухайн төсөл хэрэгжих орон нутгийн иргэдэд төсөл, хөтөлбөрийн танилцуулга хийж, санал авсан байх.

23.4.Карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч карбон бүртгэлийн системд бүртгүүлж, дараах тодорхойлолтыг авна:

23.4.1.энэ хуулийн 8.3.5-д заасан тодорхойлолт;

23.4.2.хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрт олгосон зөвшөөрсөн тухай тодорхойлолт;

23.4.3.хоёр талт болон олон талт карбон зах зээлийн хүрээнд үүссэн олон улсад шилжүүлэн тооцох бууруулалтын үр дүнгийн шилжүүлэгт олгосон зөвшөөрсөн тухай тодорхойлолт;

23.4.4.энэ хуулийн 8.3.8-д заасан тодорхойлолт.

23.5.Карбон зах зээлийн төсөлд олгох зөвшөөрсөн тухай тодорхойлолтод дараах асуудлыг тусгана:

23.5.1.үүсэх бууруулалтын үр дүнгээс Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох хэмжээ;

23.5.2.эрсдэлийн санд хуримтлуулах бууруулалтын үр дүнгийн хувь хэмжээ;

23.5.3.хүлэмжийн хийн үндэсний тооллогод харгалзах тохируулга хийх шаардлага;

23.5.4.давхар тооллого үүсгэхээс сэргийлэхэд шаардлагатай суурь мэдээлэл;

23.5.5.бууруулалтын үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох, олон улсад шилжүүлэх эсэхийг тодорхойлсон ашиглалтын зорилго;

23.5.6.зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгож байгаа бууруулалтын үр дүнгийн хамрах хүрээ, хэмжээ;

23.5.7.төслийн суурь түвшин, аргачлал, нэмэлт чанарын шаардлага;

23.5.8.хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлага;

23.5.9.сааруулалтын үр дүнгийн эхний шилжүүлэг;

23.5.10.төслийн хугацаа, сааруулалтын үр дүн үүсгэх хугацаа.

23.6.Карбон кредит болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг төсөл хэрэгжүүлэгч талуудын хооронд хуваарилах, ашиглах асуудлыг хоёр талт олон улсын хэлэлцээр, төсөл хэрэгжүүлэх гэрээгээр зохицуулна.

23.7.Энэ хуулийн 11.1-д заасан байгууллага карбон зах зээлийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний төлбөр, хураамж, шимтгэлийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

**24 дүгээр зүйл.Карбон кредитийн бүртгэл, шилжүүлэг**

24.1.Баталгаажсан карбон кредит нь карбон кредитийн бүртгэлийн системд бүртгэгдсэнээр түүнийг эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах, арилжих, захиран зарцуулах эрх үүснэ.

24.2.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслөөс үүссэн карбон кредитийн эзэмших эрхийг хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч, төслийг хэрэгжүүлсэн орон нутгийн төлөөлөл, бусад сонирхогч талуудын хооронд байгуулсан гэрээгээр тогтоох бөгөөд тухайн гэрээнд талуудын оролцоо, эрх, үүрэг, үр ашгийн хуваарилалт тусгагдсан байна.

24.3.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслөөс үүсэх кредитийг эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах, бусад хэлбэрээр захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 7.1.8-д заасан журмаар зохицуулна.

24.4.Карбон кредитийн эзэмшил, шилжүүлгийн мэдээллийг үндэсний бүртгэлд бүртгэж, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн тайланд тусгаж тайлагнана.

**25 дугаар зүйл.Хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт**

25.1.Төсөл хэрэгжүүлэгч сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжилт, тайлагнал,

баталгаажуулалтыг баталсан аргачлалын дагуу жил бүр хийж, энэ хуулийн 11.1-д заасан байгууллагад хүргүүлнэ.

25.2.Сааруулалтын үр дүнгийн баталгаажуулалт нь урьдчилсан баталгаажуулалт болон үр дүнгийн баталгаажуулалтаас бүрдэх бөгөөд баталгаажуулалтыг холбогдох олон улсын болон үндэсний стандартын дагуу итгэмжлэгдсэн, хараат бус хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

25.3.Сааруулалтын үр дүн үүсгэх төсөл, хөтөлбөрийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтыг энэ хуулийн 7.1.9-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

25.4.Энэ хуулийн 25.2-т заасан итгэмжлэгдсэн, хараат бус этгээдийг бүртгэх журмыг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлаж, хэрэгжилтийг хангана.

25.5.Сайн дурын карбон зах зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрөөс үүсэх карбон кредиттэй холбоотой хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тайланг баталгаажуулалт хийгдсэний дараа энэ хуулийн 11.1-д заасан байгууллагад хүргүүлнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## МЭДЭЭЛЛИЙН САН, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

### 26 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформ

26.1.Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформ нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллага, олон улсын байгууллагын мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтын ажиллагааг дэмжих үндэсний мэдээллийн систем байна.

26.2.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийг энэ хуулийн 26.1-д заасан үндэсний мэдээллийн системд бүртгэж, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллана.

### 27 дугаар зүйл.Хяналт шинжилгээ, үнэлгээ

27.1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, гарз хохирлыг бууруулах, технологи дамжуулах, чадавх бэхжүүлэх, ногоон санхүүжилтийн

хэрэгжилтийн үр дүнг үнэлэх хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгож, аргачлалыг батална.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан байгууллага энэ хуулийн хэрэгжилт, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, арга хэмжээ, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн үр дүнгийн үнэлгээг жил бүр хийж, хөндлөнгийн хараат бус мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан Засгийн газарт танилцуулна.

27.3.Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрийн хүрээнд батлагдсан холбогдох шийдвэр, удирдамжийн дагуу дараах тайлан, мэдээллийн ил тод байдлыг ханган тайлагнана:

27.3.1.хүлэмжийн хийн үндэсний тооллогын тайлан;

27.3.2.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайлан;

27.3.3.уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монгол Улсын үндэсний тайлан, илтгэл;

27.3.4.карбон кредит, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнгийн талаарх жил тутмын шинэчилсэн мэдээлэл бүхий тайлан;

27.3.5.уур амьсгалын санхүүжилтийн талаарх жил тутмын шинэчилсэн мэдээлэл бүхий тайлан.

27.4.Энэ хуулийн 27.3-т заасан тайлан, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангах зорилгоор дотоодын хяналт, чанарын баталгаажуулалт болон олон улсын техникийн шинжилгээнд хамруулна.

27.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, хүлэмжийн хийн ялгарал, сааруулалт болон дасан зохицох арга хэмжээний талаарх мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын стандартын дагуу ил тод мэдээлж болно.

### 28 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан, карбоны бүртгэл

28.1.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох, сааруулах арга хэмжээний талаарх мэдээллийг хадгалах, шинэчлэх мэдээллийн сантай байна.

28.2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн байгууллага уур амьсгалын

өөрчлөлттэй холбоотой холбогдох өгөгдөл, мэдээллийг хуульд заасан журмын дагуу энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

28.3.Энэ хуулийн 11.1-д заасан байгууллага хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийн систем, карбон бүртгэлийн системийг удирдлага, зохион байгуулалтаар хангана.

28.4.Карбон бүртгэлийн систем нь хүлэмжийн хийн үндэсний тооллогын систем, олон улсын холбогдох карбон бүртгэлийн системтэй уялдсан байна.

28.5.Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан, карбон бүртгэлийн систем нь уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформын бүрэлдэхүүн хэсэг байна.

28.6.Мэдээллийн сан, бүртгэлийн систем дэх өгөгдөл, мэдээллийг хууль тогтоомжид нийцүүлэн ил тод, хүртээмжтэй байлгах бөгөөд үндэсний аюулгүй байдал, нууцлалтай холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаална.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД

### 29 дүгээр зүйл.Хориглох үйл ажиллагаа

29.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцогдох карбон кредитийг энэ хуулийн 8.3-т заасан байгууллагын зөвшөөрсөн тухай тодорхойлолтгүйгээр худалдах, арилжих, бусад байдлаар шилжүүлэхийг хориглоно.

29.2.Ногоон санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө, үр дүнгийн талаар илт худал, төөрөгдүүлсэн, баталгаажаагүй мэдээлэл ашиглан тайлагнахыг хориглоно.

### 30 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[9], Зөрчлийн тухай хууль[10] болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

30.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь

[9] Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[10] Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.

гэмт хэргийн болон зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд[11] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**31 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

31.1.Энэ хуулийн 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор баталж, мөрдүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

[11] Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.

[illegible]

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

᠒᠐᠒᠖ [illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠕.᠑.᠕. [illegible];

᠕.᠑.᠖. [illegible];

᠕.᠑.᠗. [illegible];

᠕.᠑.᠘. [illegible];

᠕.᠑.᠙. [illegible];

᠕.᠑.᠑᠐. [illegible]᠃

[illegible]

[illegible]

[illegible]

᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible]

᠖.᠑. [illegible]:

᠖.᠑.᠑. [illegible];

᠖.᠑.᠒. [illegible];

᠖.᠑.᠓. [illegible];

᠖.᠑.᠔. [illegible]᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠷ᠎ᠡ ᠲᠣᠮᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠣᠳᠣᠷᠬᠠᠶᠢᠯᠠᠯᠲᠠ

᠒.᠖. ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠷ᠎ᠡ ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠬᠡᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠵᠢ ᠣᠢᠯᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠄

᠒.᠖.᠑. ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠰᠢᠭᠤᠳ᠂ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠ ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠷᠥᠯ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ᠂ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠃

᠒.᠖.᠒. ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠷᠥᠯ ᠪᠠ ᠴᠢᠨᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠳᠠᠭ ᠪᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠭᠠᠷᠭᠠᠬᠤ᠂ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ ᠳᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

᠒.᠖.᠓. ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠰᠢᠭᠤᠳ᠂ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠃

᠒.᠖.᠔. ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠰᠢᠭᠤᠳ᠂ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠳᠦ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠴᠢᠨᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠳᠠᠭ ᠪᠣᠯᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

᠒.᠖.᠕. ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠪᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ᠂ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠲᠠᠢ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ᠃

᠒.᠖.᠖. ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ᠂ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ᠂ ᠴᠢᠨᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠳᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

᠒.᠖.᠗. ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ᠂ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠲᠠᠢ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠬᠤ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ ᠳᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠳᠦ ᠣᠯᠭᠣᠬᠤ ᠵᠢ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

᠒.᠖.᠘. ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠠᠩ ᠬᠥᠮᠦᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ᠂ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠃

᠒.᠖.᠙. ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠪᠡᠷ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠠᠬᠤ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠲᠠᠯ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

᠒.᠖.᠑᠐. ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠷ ᠰᠠᠭᠤᠷᠢ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠯᠲᠡ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠠᠰᠢᠭᠯᠠᠬᠤ᠂ ᠰᠢᠨ᠎ᠡ ᠠᠭᠤᠯᠠ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠲᠠᠯ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ᠃

[illegible]

[illegible]

᠘᠂᠓᠂᠑᠒᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠓᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠔᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠕᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠖᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠗᠂ [illegible]

᠘᠂᠓᠂᠑᠘᠂ [illegible]

᠘᠂᠔᠂ [illegible]

᠘᠂᠔᠂᠑᠂ [illegible]

᠘᠂᠔᠂᠒᠂ [illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠑᠑ [illegible]

᠑᠑.᠑. [illegible]

᠑᠑.᠑.᠑. [illegible]

᠑᠑.᠑.᠒. [illegible]

᠑᠑.᠑.᠓. [illegible]

᠑᠑.᠑.᠔. [illegible]

᠑᠑.᠑.᠕. [illegible]

᠑᠑.᠑.᠖. [illegible]

᠑᠑.᠑.᠗. [illegible]

᠑᠑.᠑.᠘. [illegible]

᠑᠑.᠑.᠙. [illegible]

᠑᠑.᠑.᠑᠐. [illegible]

ᠭᠤᠷᠪᠠᠳᠤᠭᠠᠷ ᠪᠦᠯᠦᠭ

[illegible]

᠑᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ. [illegible]

᠑᠒.᠑. [illegible]

᠑᠒.᠒. [illegible]

᠑᠒.᠓. [illegible]

᠑᠒.᠔. [illegible]

[illegible]

᠑᠙.᠑. [illegible]

᠑᠙.᠒. [illegible]

᠑᠙ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ. [illegible]

᠑᠙.᠓. [illegible]

᠑᠙.᠔. [illegible]

᠑᠙.᠕. [illegible]

᠑᠙.᠖. [illegible]

᠑᠙.᠗. [illegible]

[illegible]

᠑᠑.᠑. [illegible]

᠑᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

᠑᠒.᠑. [illegible]

᠑᠒.᠒. [illegible]

[illegible]

᠑᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

᠑᠓.᠑. [illegible]

᠑᠓.᠒. [illegible]

᠑᠓.᠓. [illegible]

ᠶᠠᠪᠤᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠤᠯᠤᠨ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠳᠦᠷᠪᠡᠨ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠤᠨ ᠡᠳᠦᠷ ᠳᠦ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢ ᠶᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠔ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠳᠣᠭᠤᠷ ᠤᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠲᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠕ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠩᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠳᠠᠯᠠᠯᠠᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠖ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠭᠰᠡᠨ ᠠᠰᠠᠭᠤᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠠᠯᠠ ᠪᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠘ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠲᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠙ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠓ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠐ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠲᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠰ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃

᠑᠙.᠒. ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠳᠤ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠤᠳᠤᠷᠢᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠬᠦ ᠳᠦᠷᠢᠮ ᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠰᠠᠶᠢᠳ ᠪᠠᠲᠤᠯᠠᠨ᠎ᠠ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠙.᠑ — ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠪᠣᠯᠭᠠᠬᠤ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠭᠤᠯᠬᠤ᠃

᠑᠙.᠓. ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠬᠤ ᠲᠤᠰᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠬᠠᠭᠤᠳᠠᠰᠤ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠳᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠰᠠᠶᠢᠳ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠪᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠡᠷᠬᠡ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ ᠪᠠ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠨ᠎ᠠ᠃

᠑᠙.᠔. ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ ᠢ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠢᠴᠡᠭᠦᠯᠦᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠨ᠎ᠠ᠃

ᠲᠠᠪᠤᠳᠤᠭᠠᠷ ᠪᠦᠯᠦᠭ
ᠪᠤᠰᠤᠳ ᠵᠦᠢᠯ

᠒᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠷᠢᠴᠡᠭᠰᠡᠨ

᠒᠐.᠑. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠵᠦᠷᠢᠴᠡᠭᠰᠡᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯᠲᠠᠨ ᠳᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠬᠠᠭᠠᠴᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ᠂ ᠬᠢᠮᠠᠳ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ᠂ ᠡᠷᠦᠭᠦᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠬᠦᠯᠢᠶᠡᠯᠭᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐.᠒. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠬᠦ᠂ ᠰᠤᠷᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠨ ᠮᠦᠷᠳᠡᠯᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐.᠓. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠙.᠒ — ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠪᠣᠯᠭᠠᠬᠤ᠂ ᠬᠣᠶᠠᠷ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠣᠭᠤᠷᠤᠨᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠨ ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠷᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠃

᠒᠐.᠔. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠵᠦᠷᠢᠴᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠮᠦᠷᠳᠡᠯᠡᠨ᠎ᠡ᠃

᠒᠐.᠔.᠑. [illegible]

᠒᠐.᠔.᠒. [illegible]

᠒᠐.᠔.᠓. [illegible]

᠒᠐.᠔.᠔. [illegible]

᠒᠐.᠔.᠕. [illegible]

᠒᠐.᠔.᠖. [illegible]

᠒᠐.᠕. [illegible]

᠒᠐.᠕.᠑. [illegible]

᠒᠐.᠕.᠒. [illegible]

᠒᠐.᠕.᠓. [illegible]

᠒᠐.᠕.᠔. [illegible]

᠒᠐.᠕.᠕. [illegible]

᠒᠐.᠕.᠖. [illegible]

᠒᠐.᠖. [illegible] ᠒᠐.᠕ – [illegible]

᠒᠐.᠗. [illegible] ᠪᠠᠢᠨ᠎ᠠ᠃

᠒᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible]

᠒᠑.᠑. [illegible]

᠒᠑.᠒. [illegible] ᠪᠠᠢᠨ᠎ᠠ᠃

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]
[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]
[illegible]

[illegible]

[illegible]

᠓᠓.᠔. [illegible] ᠄

᠓᠓.᠔.᠑. [illegible] ;

᠓᠓.᠔.᠒. [illegible] ;

᠓᠓.᠔.᠓. [illegible] ;

᠓᠓.᠔.᠔. [illegible] ;

᠓᠓.᠔.᠕. [illegible] ;

᠓᠓.᠔.᠖. [illegible] ;

᠓᠓.᠔.᠗. [illegible] ;

᠓᠓.᠔.᠘. [illegible] ;

᠓᠓.᠔.᠙. [illegible] ;

᠓᠓.᠔.᠑᠐. [illegible] ᠃

᠓᠓.᠕. [illegible] ᠃

᠓᠓.᠖.᠓. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠑.᠑ – ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ [illegible] ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ᠂ [illegible] ᠃

᠒᠑ [illegible]

᠒᠑.᠑. [illegible]

᠒᠑.᠒. [illegible]

᠒᠑.᠓. [illegible]

᠒᠑.᠔. [illegible]

᠒᠒ [illegible]

᠒᠒.᠑. [illegible]

᠒᠒.᠒. [illegible]

᠒᠒.᠓. [illegible]

᠖᠗.᠓. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠤᠨ ᠵᠠᠬᠢᠷᠭᠠᠨ ᠤ ᠬᠡᠯᠲᠡᠰ · ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠲᠦᠷᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠢ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠲᠠᠢ ᠪᠣᠯᠭᠠᠨ ᠠ᠃

᠖᠗.᠓.᠑. ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠄

᠖᠗.᠓.᠒. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠯᠳᠦᠬᠦᠨ ᠳᠦ ᠤᠯᠤᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠄

᠖᠗.᠓.᠓. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠣᠷᠤᠨᠳᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ᠄

᠖᠗.᠓.᠔. ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠄

᠖᠗.᠓.᠕. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠯᠳᠦᠬᠦᠨ ᠳᠦ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠃

᠖᠗.᠔. ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠳᠦ ᠖᠗.᠓ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ · ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠵᠢᠯ ᠪᠠ ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠵᠢᠷᠤᠮ · ᠬᠢᠷᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠢᠵᠠᠭᠠᠷᠯᠠᠯ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃

᠖᠗.᠕. ᠡᠳ᠋ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠷᠤᠭ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠳᠦᠷᠢᠮ · ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠪᠣᠯ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠠ ᠪᠣᠰᠤᠭ᠎ᠠ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃

᠖᠘ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠳᠤ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ
ᠡᠷᠬᠡ · ᠦᠦᠷᠭᠡ ᠪᠠ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ

᠖᠘.᠑. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠴᠢ · ᠬᠠᠮᠠᠲᠤ ᠪᠦᠲᠦᠭᠡᠯ · ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠮᠥᠨ · ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠣᠷᠠᠯᠬᠠ · ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃

ᠡᠭᠦᠳᠦᠭᠰᠡᠨ ᠪᠠ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠᠢ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠬᠦ · ᠵᠢᠷᠤᠮᠯᠠᠬᠤ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠃

᠖᠘.᠒. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠴᠢ ᠪᠣᠯ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ · ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠬᠦ ᠳᠦ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠬᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠪᠠ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ · ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠢᠵᠠᠭᠠᠷ ᠲᠠᠢ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠪᠠᠷ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠᠢ ᠪᠣᠯᠪᠠ᠃ ᠖᠘.᠑ — ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠳᠦ ᠪᠠᠭᠲᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢᠯᠡᠭᠴᠢ ᠤ᠂ᠬᠦᠷᠡᠯᠰᠦᠬ

ᠲᠣᠪᠴᠢᠶᠠᠨ ᠬᠠᠭᠤᠯᠢ᠄

᠑. ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠬᠤᠳᠠᠯᠳᠤᠭᠠᠨ ᠤ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠒. ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠵᠢᠷᠤᠮ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠗ ᠣᠨ ᠤ ᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠓. ᠠᠷᠠᠳ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠔. ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠕ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠕. ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠰᠦᠭ᠂ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠒᠐᠐᠕ ᠣᠨ ᠤ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠖. ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠘ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠗. ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠕ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠘. ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠙ ᠣᠨ ᠤ ᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠙. ᠲᠦᠷᠢᠶᠡᠰ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠖ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠑᠐. ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠔ ᠣᠨ ᠤ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

᠑᠑. ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠰᠠᠩ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ «ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠰᠡᠳᠬᠦᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠶᠢᠲᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ᠃

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг, 24 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр — Улаанбаатар хот

## АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хөрөнгө оруулахыг” гэснийг “зам тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инноваци, үйлдвэрлэлийн арга нэвтрүүлэхийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** — **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

## БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.1.26 дахь заалт нэмсүгэй:

“33.1.26.барилга байгууламж, үйл ажиллагаанаас ялгарч болох хүлэмжийн хийн хэмжээг тогтоох;”

**2 дугаар зүйл.**Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.26 дахь заалтын дугаарыг “33.1.27” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, карбон зах зээлийг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиар зохицуулна.”

**2/37 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан мэдээллийг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд заасан үндэсний зохицуулагч байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн санд оруулсан байна.”

**2 дугаар зүйл.**Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дугаарыг “3” гэж, 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын “уур амьсгал;” гэснийг “уур амьсгалын өөрчлөлт;” гэж, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “1-7, 9-12,” гэснийг “1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12,” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “9-12,” гэснийг “8, 9, 10, 11, 12,” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “үнэлгээ хийнэ.” гэснийг “үнэлгээ хийх бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, уур амьсгалын төсөөллийн мэдээллийг харгалзан үзнэ.” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Тариалангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтын “тохиромжгүй болсон” гэсний дараа “, уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлсөн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “эргэлтэд оруулах” гэсний дараа “, газар тариалангийн салбарт нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи, инноваци, үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠣᠨ — ᠤ ᠳᠣᠯᠣᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠲᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠩ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠩ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 14 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 14.2.1 ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠲᠣᠬᠢᠷᠠᠮᠵᠢ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ «᠂ ᠠᠭᠠᠷ ᠠᠮᠢᠰᠬᠤᠯ ᠤᠨ ᠦᠪᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠳᠦ ᠰᠦᠷᠭᠡᠭᠦ ᠪᠡᠷ ᠨᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠰᠡᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ 19 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 19.7 ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠡᠷᠭᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ» ᠭᠡᠰᠡᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ «᠂ ᠭᠠᠵᠠᠷ ᠲᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠩ ᠤᠨ ᠰᠠᠯᠪᠤᠷᠢ ᠳᠤ ᠨᠡᠭᠦᠷᠡᠰᠦᠲᠦᠷᠦᠭᠴᠢ ᠪᠠᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ᠂ ᠠᠭᠠᠷ ᠠᠮᠢᠰᠬᠤᠯ ᠤᠨ ᠦᠪᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠳᠦ ᠲᠡᠰᠪᠦᠷᠢ ᠲᠠᠢ ᠲᠧᠻᠨᠣᠯᠣᠭᠢ᠂ ᠢᠨᠨᠣᠸᠠᠼᠢ᠂ ᠦᠢᠯᠡᠳᠪᠦᠷᠢᠯᠡᠯ ᠦᠨ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠨᠡᠪᠲᠡᠷᠡᠭᠦᠯᠬᠦ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠨᠡᠮᠡᠭᠲᠦᠭᠡᠢ᠃

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠣᠨ — ᠤ ᠳᠣᠯᠣᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠠᠭᠠᠷ ᠠᠮᠢᠰᠬᠤᠯ ᠤᠨ ᠦᠪᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰ᠂ ᠪᠢᠮᠪᠠᠼᠣᠭᠲᠤ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “хэрэгжүүлж,” гэсний дараа “уур амьсгалын өөрчлөлт,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠬᠣᠶᠠᠷ ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠬᠣᠷᠢᠨ ᠵᠢᠷᠭᠤᠭᠠᠨ ᠣᠨ ᠤ ᠳᠣᠯᠣᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠡᠳᠦᠷ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠬᠣᠲᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠣᠲᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠳᠣᠯᠣᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗.᠑.᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠂» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ «ᠠᠭᠠᠷ ᠠᠮᠢᠰᠬᠤᠯ ᠤᠨ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ᠂» ᠭᠡᠵᠦ ᠨᠡᠮᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠢ᠃

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠣᠶᠠᠷ ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠬᠣᠷᠢᠨ ᠵᠢᠷᠭᠤᠭᠠᠨ ᠣᠨ ᠤ ᠳᠣᠯᠣᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠠᠭᠠᠷ ᠠᠮᠢᠰᠬᠤᠯ ᠤᠨ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰ. ᠪᠢᠮᠪᠠᠴᠣᠭ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “үндэсний хөтөлбөрийг” гэснийг “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод заасан арга хэмжээг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

## МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад “иргэдэд сурталчлах” гэсний дараа “, цэргийн албаны офицер, ахлагч, алба хаагчдад сургалт зохион байгуулах” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠓ — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠦ ᠺᠣᠮᠢᠰ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠦ ᠺᠣᠮᠢᠰ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠓᠓ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓᠓.᠑.᠒ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠳᠤ «ᠢᠷᠭᠡᠳ ᠲᠦ ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠠᠬᠤ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ «᠂ ᠴᠡᠷᠢᠭ ᠦᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠣᠹᠢᠼᠧᠷ᠂ ᠠᠬᠠᠯᠠᠭᠴᠢ᠂ ᠠᠯᠪᠠ ᠬᠠᠭᠠᠭᠴᠢᠳ ᠲᠤ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ» ᠭᠡᠵᠦ ᠨᠡᠮᠡᠭᠲᠦᠭᠡᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰ᠂ ᠪᠢᠮᠪᠠᠴᠣᠭᠲᠤ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

## Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах, хүүхдэд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, шим тэжээллэг хоол хүнсээр үйлчилж, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа нэг суралцагчид ногдох хоолны зардлын нормативыг инфляцын түвшин, суралцагчийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээлийн хэрэгцээг харгалзан нэмэгдүүлж, жил бүрийн улсын төсөвт тусгах;

2/ерөнхий боловсролын сургуулийн 6-7 дугаар ангийн суралцагчдыг 2027-2028 оны хичээлийн жилээс, 8-9 дүгээр ангийн суралцагчдыг 2028-2029 оны хичээлийн жилээс, 10-12 дугаар ангийн суралцагчдыг 2029-2030 оны хичээлийн жилээс эхлэн үдийн хоолны үйлчилгээнд тогтвортой, тэгш, хүртээмжтэй байдлаар хамруулах;

3/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах хүний нөөц, түүний цалин, тоног төхөөрөмжийн хангалт, нийлүүлэлт, байрын засвар үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх;

4/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, ундны цэвэр усыг эрүүл ахуй, стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

5/эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт хооллох соёл, зөв дадал, тэнцвэртэй хооллолт, шим тэжээлийн тухай суурь ойлголт, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын агуулгыг тусгаж, эрүүл хооллох дадал эзэмшүүлэх, эрүүл мэндийг дэмжих зан үйлийг төлөвшүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор үдийн хоолны цагийг нэмэгдүүлэх;

6/суралцагчдын өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдалд хоол, шим тэжээлийн үзүүлэх нөлөөлөл, зан үйлийн судалгааг хийхэд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгаж, түүнийг жил бүр зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэх;

7/судалгаанд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрдэс, амин дэмээр баяжуулах норм, нормативыг баталж, баяжуулсан болон органик хүнсийг хангах нийлүүлэх бодлого хэрэгжүүлэх, хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг бий болгон тэргүүн ээлжид орон нутгийн хувийн хэвшил, нөхөрлөл, хоршоодыг дэмжих;

8/хоол зүйч, тогоочийг бэлтгэх, тэдний мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авах;

9/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчин, эрүүл ахуй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;

10/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтарсан хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.Энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө, шаардагдах төсөв, санхүүжилтийн тооцоог батлах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжилтийн явц, үр дүнг 2030 он хүртэл хугацаанд жил бүрийн 06 дугаар сард Монгол Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 53 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4, 5, 6 дахь дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо /О.Номинчимэг/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

Монгол Улсын Их Хурлын 2026 оны
28 дугаар тогтоолын хавсралт

## АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| Д/д | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин 2027 | 2028 | 2029 | 2030 | Хүрэх үр дүн | Хариуцах байгууллага | Мэдээллийн эх сурвалж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.1/ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа нэг суралцагчид ногдох хоолны зардлын нормативыг инфляцын түвшин, суралцагчийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээлийн хэрэгцээг харгалзан нэмэгдүүлж, жил бүрийн улсын төсөвт тусгах; | Бага ангийн нэг суралцагчид ногдох хоолны түүхий эдийн зардлын норматив /мян.төг/ | 2500 | 3500 | 4000 | 4500 | 5000 | Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шим тэжээл бүхий хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| | | Дотуур байранд амьдарч байгаа нэг хүүхдэд ногдох хоолны түүхий эдийн зардлын норматив /мян.төг/ | 6000-6300 | 8000-8300 | 10000-11000 | 12000-13000 | 14000-15000 | | | |
| 2 | 1.2/ерөнхий боловсролын сургуулийн 6-7 дугаар ангийн суралцагчдыг 2027-2028 оны хичээлийн жилээс, 8-9 дүгээр ангийн суралцагчдыг 2028-2029 оны хичээлийн жилээс, 10-12 дугаар ангийн суралцагчдыг 2029-2030 оны хичээлийн жилээс эхлэн үдийн хоолны үйлчилгээнд тогтвортой, тэгш, хүртээмжтэй байдлаар хамруулах; | 6-7 дугаар ангийн нэг суралцагчид ногдох хоолны түүхий эдийн зардлын норматив /мян.төг/ | - | 4000 | 4500 | 5000 | 5500 | Хүүхэд бүрд тэгш, хүртээмжтэй шим тэжээл бүхий хоолны үйлчилгээг хүргэж, өсвөр насны хүүхдийн зохисгүй хооллолтын эрсдэлийг бууруулна. | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| | | 8-9 дүгээр ангийн нэг суралцагчид ногдох хоолны түүхий эдийн зардлын норматив /мян.төг/ | - | - | 5000 | 5500 | 6000 | | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| | | 10-12 дугаар ангийн нэг суралцагчид ногдох хоолны түүхий эдийн зардлын норматив /мян.төг/ | - | - | - | 6000 | 6500 | | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.3/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах хүний нөөц, түүний цалин, тоног төхөөрөмжийн хангалт, нийлүүлэлт, байрын засвар үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх; | Хүний нөөцийн цалингийн зардал /тэрбум.төг/ | 59.3 | 78.3 | 98.6 | 121.5 | 140.1 | Сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| | | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангуулахад тухайн жилд шаардагдах зардал /тэрбум.төг/ | 5.6 | 27.7 | 31.1 | 32.8 | 25.8 | Хоол хүнсний эрүүл ахуй, баталгаат байдал хангагдана. | Боловсролын яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| 4 | 1.4/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, ундны цэвэр усыг эрүүл ахуй, стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх; | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан сургууль /хувь/ | 60 | 70 | 80 | 85 | 90 | Эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангах боломж бүрдүүлнэ. | Боловсролын яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам | Салбарын статистик мэдээ |
| | | Стандартад заасан ундны цэвэр усны төхөөрөмжөөр хангагдсан сургууль /тоо/ | 572 | 612 | 657 | 692 | 717 | Усны зохистой хэрэглээ нэмэгдэж, эрүүл зөв дадал хэвшлийг төлөвшүүлнэ. | Боловсролын яам, Сангийн яам | Салбарын статистик мэдээ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 1.5/эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт хооллох соёл, зөв дадал, тэнцвэртэй хооллолт, шим тэжээлийн тухай суурь ойлголт, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын агуулгыг тусгаж, эрүүл хооллох дадал эзэмшүүлэх, эрүүл мэндийг дэмжих зан үйлийг төлөвшүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор үдийн хоолны цагийг нэмэгдүүлэх; | Агуулгыг тусгасан хичээлийн хөтөлбөр /тоо/ | 2 | 5 | 7 | 9 | 12 | Хүүхдийн тав тухтай хооллох орчныг бүрдүүлэх замаар эрүүл мэнд, зан төлөвшлийн зохистой дадлыг эзэмшүүлнэ. | Боловсролын яам, Эрүүл мэндийн яам | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр |
| | | Үдийн хоолны цагийг нэмэгдүүлсэн сургууль /хувь/ | - | 20 | 40 | 50 | 60 | | | Салбарын статистик мэдээ |
| 6 | 1.6/суралцагчдын өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдалд хоол, шим тэжээлийн үзүүлэх нөлөөлөл, зан үйлийн судалгааг хийхэд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгаж, түүнийг жил бүр зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэх; | Түүвэр судалгаа /жил бүр/ Үндэсний хэмжээний судалгаа /жилд 1 удаа/ | 2022-2024 онд хийсэн судал-гааны тайлан | 1 | 2 | 1 | 1 | Эрүүл мэндийг дэмжих бодлого, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлно. | Эрүүл мэндийн яам, Боловсролын яам | Судалгааны тайлан |
| | | Судалгаанд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусган хэрэгжүүлсэн байдал | - | Улсын төсөв | Улсын төсөв | Улсын төсөв | Улсын төсөв | Судалгаа хийх нөхцөл бүрдэнэ. | Эрүүл мэндийн яам, Сангийн яам | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 1.7/судалгаанд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрдэс, амин дэмээр баяжуулах норм, нормативыг баталж, баяжуулсан болон органик хүнсийг хангах нийлүүлэх бодлого хэрэгжүүлэх, хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг бий болгон тэргүүн ээлжид орон нутгийн хувийн хэвшил, нөхөрлөл, хоршоодыг дэмжих; | Сургуулийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж байгаа баяжуулсан болон органик хүнсний эзлэх хувь | - | +5 | +5 | +5 | +5 | Хүүхдийн өсөлт хөгжил, дархлаа, оюуны болон бие бялдрын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Хүүхдийн эрүүл мэндийн статистик үзүүлэлт |
| | | Нийт худалдан авалтад орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь | 15 | 25 | 35 | 45 | 55 | Орон нутгийн үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад бодит нөлөө үзүүлнэ. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Салбарын статистик мэдээ |
| 8 | 1.8/хоол зүйч, тогоочийг бэлтгэх, тэдний мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авах; | Сургалтад хамрагдсан хүний тоо | 2230 | 2000 | 2000 | 2000 | 2000 | Хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ. | Боловсролын яам | Салбарын статистик мэдээ |
| | | Мэргэжлийн хоол зүйчээр хангагдсан сургууль /тоо/ | 302 | 406 | 509 | 612 | 717 | | Боловсролын яам | Салбарын статистик мэдээ |
| 9 | 1.9/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчин, эрүүл ахуй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах; | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын үнэлгээ /хувь/ | 73 | 78 | 83 | 88 | 93 | Хүүхдэд ээлтэй сургуулийн орчин бүрдүүлж, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлнэ. | Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсролын яам | Хяналт шалгалтын дүн |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | 1.10/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтарсан хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамжийн түвшин /хувь/ | 81.7 | 86 | 91 | 96 | 100 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, ил тод байдал сайжирч, хариуцлага нэмэгдэнэ. | Боловсролын яам | Салбарын статистик мэдээ |

---oOo---

[illegible] ᠒᠐᠒᠖ [illegible]

| ᠳ/ᠳ | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] ᠒᠐᠒᠗ | ᠒᠐᠒᠘ | ᠒᠐᠒᠙ | ᠒᠐᠓᠐ | [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ᠑ | [illegible] | [illegible] | ᠖᠐᠐᠐ — ᠗᠕᠐᠐ | ᠔᠐᠐᠐ — ᠔᠕᠐᠐ | ᠑᠐᠐᠐᠐ — ᠑᠑᠐᠐᠐ | ᠑᠔᠐᠐᠐ — ᠑᠖᠐᠐᠐ | ᠑᠗᠐᠐᠐ — ᠑᠕᠐᠐᠐ | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | ᠘᠕᠐᠐ | ᠔᠕᠐᠐ | ᠖᠐᠐᠐ | ᠗᠕᠐᠐ | ᠒᠐᠐᠐ | | | |
| ᠒ | [illegible] | [illegible] | — | ᠖᠐᠐᠐ | ᠗᠕᠐᠐ | ᠒᠐᠐᠐ | ᠒᠐᠐᠐ | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | — | — | ᠒᠐᠐᠐ | ᠒᠒᠐᠐ | ᠖᠐᠐᠐ | | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | — | — | — | ᠖᠐᠐᠐ | ᠗᠕᠐᠐ | | [illegible] | [illegible] |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ᠑ | [illegible] ᠖.᠑/ [illegible] | [illegible] | — | ᠔᠐ | ᠒᠐ | ᠑᠐ | ᠖᠐ | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | ᠔ | ᠑ | ᠘ | ᠗ | ᠖᠔ | | | [illegible] |
| ᠒ | [illegible] ᠖.᠒/ [illegible] | [illegible] | ᠑᠘᠔ | ᠒᠑᠔ | ᠒᠑᠘ | ᠒᠗᠔ | ᠘᠖᠘ | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | ᠖᠐ | ᠘᠐ | ᠕᠐ | ᠕᠑ | ᠗᠐ | [illegible] | [illegible] | [illegible] |
| ᠓ | [illegible] ᠖.᠓/ [illegible] | [illegible] | ᠑.᠖ | ᠔᠘.᠘ | ᠓᠖.᠖ | ᠔᠔.᠕ | ᠔᠑.᠕ | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | ᠑᠗.᠓ | ᠘᠕.᠓ | ᠗᠕.᠖ | ᠖᠔᠖.᠑ | ᠖᠒᠐.᠖ | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | |
|---|---|
| ᠒ | ᠑᠐ |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | ᠓ |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | ᠑᠐᠐ |
| [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] |
| ᠳᠣᠷᠨᠠᠲᠤ | ᠳᠤᠮᠳᠠᠭᠤᠪᠢ |

---oOo---

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

## Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Байнгын хороо буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠖ — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠙᠔ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

## ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠢ ᠪᠤᠴᠠᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠴᠢᠭᠤᠯᠭᠠᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠤ ᠳᠡᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠖᠒.᠖ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠡᠴᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

1. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠠᠴᠠ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠗ — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠳᠤ ᠥᠷᠭᠦᠨ ᠮᠡᠳᠦᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠬᠠᠮᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠢ ᠪᠤᠴᠠᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠢ ᠳᠠᠭᠠᠯᠳᠤᠭᠤᠯᠤᠨ ᠣᠷᠤᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠤᠰᠤᠳ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠦᠳ ᠢ ᠠᠨᠭᠬᠠᠨ ᠤ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠬᠦ ᠡᠴᠡ ᠲᠠᠲᠠᠭᠠᠯᠭᠠᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠳᠤ ᠨᠢ ᠪᠤᠴᠠᠭᠠᠭᠰᠠᠭᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠰᠠᠭᠠᠢ ᠪᠡᠨ ᠪᠤᠴᠠᠭᠠᠬᠤ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠬᠦ ᠪᠡᠷ ᠪᠤᠴᠠᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠋ᠠ. ᠤᠯᠠᠭᠠᠨᠬᠦᠦ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр — Дугаар 43 — Улаанбаатар хот

**“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 76 дугаар зүйлийн 76.10 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 117 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ”-ний “5 760 000” гэснийг “6 560 000” гэж, “5 580 000” гэснийг “6 380 000” гэж, мөн тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ”-ний “5 760 000” гэснийг “6 560 000” гэж, “5 580 000” гэснийг “6 380 000” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠔ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠓ — ᠨ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠒᠖ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

«ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠩ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ» ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠭᠤᠯᠤᠨ ᠠᠪᠬᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠕ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠕.᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠂ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠙ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠙.᠑.᠓ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠯᠭᠠᠯ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ/ — ᠶᠢᠨ ᠒᠔ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠔.᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠂ ᠘᠖ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠘᠖.᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠡᠴᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ᠄

᠑. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ «ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠰᠠᠩ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ» ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠖᠖᠖ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠓ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠳᠤ ᠪᠠᠭᠲᠠᠭᠰᠠᠨ «ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶᠡᠨ ᠦ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠳᠦᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭ᠃ ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠢᠯᠡᠭᠦᠦ ᠲᠡᠭᠡᠯ ᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠳᠦᠨ» — ᠶᠢᠨ «᠒ ᠔᠙᠒ ᠐᠐᠐» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠒ ᠕᠙᠒ ᠐᠐᠐» ᠭᠡᠵᠦ᠂ «᠒ ᠑᠐᠑ ᠐᠐᠐» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠒ ᠓᠐᠑ ᠐᠐᠐» ᠭᠡᠵᠦ᠂ ᠮᠥᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠳᠤ ᠪᠠᠭᠲᠠᠭᠰᠠᠨ «ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ ᠶᠢᠨ ᠢᠯᠡᠭᠦᠦ ᠲᠡᠭᠡᠯ ᠦᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠳᠦᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭ ᠦᠨ ᠵᠠᠷᠤᠯᠳᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠣᠷᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠢᠯᠡᠭᠦᠦ ᠲᠡᠭᠡᠯ ᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠳᠦᠨ» — ᠶᠢᠨ «᠒ ᠔᠙᠒ ᠐᠐᠐» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠒ ᠕᠙᠒ ᠐᠐᠐» ᠭᠡᠵᠦ᠂ «᠒ ᠑᠐᠑ ᠐᠐᠐» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠒ ᠓᠐᠑ ᠐᠐᠐» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠰᠡᠭᠡᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ
ᠳ᠋ᠠ.ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠭᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

**Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэр болох эрчим хүч, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, барилга, хог хаягдал зэрэг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зорилттой уялдуулан хэрэгжүүлэх;

3/уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформыг уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан, карбоны бүртгэл, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийн системтэй холбон, иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл солилцох, бүртгэл хөтлөх, тайлагнах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

4/боловсролын сургалтын байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5/Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаар авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн тайланг 2027 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /М.Мандхай/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ [illegible] ᠡᠳᠦᠷ — ᠳ᠋ᠤᠭᠠᠷ [illegible] — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔.᠑ [illegible] ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠴᠢᠭᠤᠯᠭᠠᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠤ ᠳᠡᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ [illegible] ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ [illegible] ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠠᠴᠠ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ᠄

᠑. [illegible]

᠒. [illegible]

᠓. [illegible]

᠔. [illegible]

᠕. [illegible]

᠔/ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠢᠷᠭᠡᠨ ᠠᠶᠤᠯᠭᠦᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠶᠢᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠮᠯᠠᠯ · ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠶᠢᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠢ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠳᠤ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠬᠦ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠕᠂ ᠡᠨᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠠᠢ ᠬᠠᠮᠲᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠩᠭᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ · ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠭᠦᠯᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠰᠠᠨ /ᠵ᠂ ᠰᠠᠢᠨᠪᠠᠶᠠᠷ/ — ᠢ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠭᠠᠷ ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠨ· ᠪᠤᠯᠤᠷᠴᠡᠴᠡᠭ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

**Зарим Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар тус тус сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын, Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

**Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Дашзэвгийн Мягмарсүрэн, Сандагийн Од-Эрдэнэ, Маналжавын Төрманлай нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Сүхбаатарын Алтанцэцэг, Доржсүрэнгийн Батсүх, Ванжилийн Бат-Эрдэнэ, Наваанпэрэнлэйн Жанцан, Дэмбэрэлийн Өлзийбаатар нарыг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑ — ᠨ ᠡᠳᠦᠷ　　ᠳ᠋ᠤᠭᠠᠷ [illegible]　　ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

[illegible]

᠑· [illegible]

᠒· [illegible]

᠓· [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ　　[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

**Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Нэргүйн Мягмарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

[illegible]

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 6
**Индекс: 200003**